"МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО" ГҮТББ
БАТЛАВ.
ТЭРГҮҮН ..... А.БАТДАВАА
2020 оны 08 дугаар сарын 18 өдөр

ПАРАГЛАЙДИНГИЙН СПОРТЫН ЦОЛ, ЗЭРГИЙН АНГИЛАЛ ТОГТООХ, ЦОЛ, ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ: ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1 Параглайдингийн спортын төрөл, тэдгээрийн цол, зэргийн ангилал тогтоох, болзол хангасан тамирчин, шүүгчид цол, зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Параглайдингийн спортын цол, зэргийг Монгол улсын иргэнд олгоно.

1.3 Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалтыг үндэслэн тамирчин, шүүгчдэд Параглайдингийн спортын цол, зэргийг нөхөн олгож болно.

ХОЁР: ТӨРӨЛ, ЦОЛ, ЗЭРГИЙН АНГИЛАЛ ТОГТООХ

2.1 Тамирчид, шүүгчдэд олгох спортын цол, зэрэг нь дараах ангилалтай байна.

2.2 Цол:

2.2.1 Олон улсын хэмжээний мастер
2.2.2 Спортын мастер
2.2.3 Спортын дэд мастер

2.3 Зэрэг:

2.3.1 1 дугаар зэрэг
2.3.2 2 дугаар зэрэг
2.3.3 3 дүгаар зэрэг

2.4 Шүүгчдэд олгох цол зэрэг нь дараах ангилалтай байна.

2.4.1 Улсын шүүгч
2.4.2 1 дүгээр зэргийн шүүгч
2.4.3 2 дугаар зэргийн шүүгч

2.5 Цол, зэрэг олгох шалгуур тогтоохдоо дараах шалгуурыг баримтална. Үүнд:

2.5.1 ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР (ОУХМ)-ЫН БОЛЗОЛ

2.5.1.1 Дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд аль нэг төрөл болон ангилалаар баг эсвэл хувийн дүнгээр медальт байр эзэлбэл

2.5.1.2 Аль нэг төрлөөр тив, дэлхийн рекордыг шинэчлэн тогтоовол

2.5.1.3 Дэлхийн чансааны 10-т жагсаж энэхүү амжилтаа 6 сарын турш хадгалвал

2.5.1.4 Хүснэгтийн болзол хангавал

2.5.2 СПОРТЫН МАСТЕР (СМ)-ЫН БОЛЗОЛ

2.5.2.1 FAI-н гишүүн 7-оос доошгүй орон оролцсон албан ёсны олон улсын (FAI, Категори 2) тэмцээнд аль нэг төрөл болон ангилалаар хувийн дүнгээр түрүүлж нэгдүгээр байр эзэлвэл

2.5.2.2 Аль нэг төрөл болон ангилалаар улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа түрүүлбэл

2.5.2.3 Дэлхийн чансааны 20-т жагсаж энэхүү амжилтаа 6 сарын турш хадгалвал

2.5.2.4 Хүснэгтийн болзол хангавал

2.5.3 СПОРТЫН ДЭД МАСТЕР (СДМ)-ЫН БОЛЗОЛ

2.5.3.1 FAI-н гишүүн 7-оос доошгүй орон оролцсон албан ёсны олон улсын (FAI, Категори 2) тэмцээнд аль нэг төрөл болон ангилалаар медальт байр эзэлвэл

2.5.3.2 Дотоодын тэмцээнд аль нэг төрөл болон ангилалаар 3 удаа түрүүлвэл

2.5.3.3 Хүснэгтийн болзол хангавал

2.5.4 1-Р ЗЭРГИЙН БОЛЗОЛ

2.5.4.1 Дотоодын тэмцээнүүд дээр цол зэргийн нормативыг хангасан, мөн 50-аас доошгүй цагийн logbook-ээр баталгаажих нислэг хийсэн бол

2.5.5 2-Р ЗЭРГИЙН БОЛЗОЛ

2.5.5.1 Дотоодын тэмцээнүүд дээр цол зэргийн нормативыг хангасан, мөн 30-аас доошгүй цагийн logbook-ээр баталгаажих нислэг хийсэн бол

2.5.6 3-Р ЗЭРГИЙН БОЛЗОЛ

2.5.6.1 Дотоодын тэмцээнүүд дээр цол зэргийн нормативыг хангасан, мөн 20-оос доошгүй цагийн logbook-ээр баталгаажих нислэг хийсэн, бие даан холын зайн нислэг үйлдэх чадвартай бол

2.5.7 УЛСЫН ШҮҮГЧ

2.5.7.1 Улс, олон улсын чанартай тэмцээнийг шүүсэн туршлага, шүүгчийн мэргэжлийн сургалт семинарт хамрагдсан байдал, МПХ-ны Шүүгчийн зөвлөлийн шалгалтын дүн, шийдвэрийг үндэслэх, шүүгчийн logbook-ээр баталгаажсан байна.

2.5.8 1 ДҮГЭЭР ЗЭРГИЙН ШҮҮГЧ

2.5.8.1 Жил бүрийн шүүгчдийн сургалтанд хамрагдаж онолын шалгалтанд 80-аас доошгүй хувиар тэнцэж улсын чанартай тэмцээний 1,2-р шүүгчээр ажилласан хангалттай үнэлгээтэй шүүж байгаа, шүүгчийн logbook-ээр баталгаажсан байна.

2.5.8.2 Спортын 3-р зэргээс дээш зэрэгтэй, шүүгчийн онолын сургалтанд хамрагдаж 70-аас дээш хувиар тэнцсэн тамирчид.

2.5.9 2 ДУГААР ЗЭРГИЙН ШҮҮГЧ

2.5.9.1 Жил бүрийн шүүгчдийн сургалтанд хамрагдаж онолын шалгалтанд 70-аас доошгүй хувиар тэнцэж улсын чанартай болон орон нутгийн чанартай тэмцээний туслах шүүгчээр ажиллан шүүгчдийн зөвлөлөөс албан ёсоор зөвшөөрөл авсан шүүгчдэд, шүүгчийн logbook-ээр баталгаажсан байна.

2.5.9.2 Спортын Р3-р дунд шатны түвшний нисгэгчийн зэрэгтэй, шүүгчийн онолын сургалтанд хамрагдаж 70-аас дээш хувиар тэнцсэн тамирчид

ГУРАВ: СПОРТЫН ЦОЛ, ЗЭРГИЙН ШАЛГУУР, НОРМАТИВ

3.1 Дараах нормативыг ханган биелүүлсэн тохиолдолд цол, зэргийг олгоно.

3.1.1 ХОЛЫН ЗАЙН ТӨРӨЛ (CROSS COUNTRY)

Холын зайн төрөлд дараах үзүүлэлтүүдээр нислэгийн зам бичих төхөөрөмжийн бичлэгийг үндэслэн амжилтыг тооцно.

Шалгуур	Цол зэрэг					
	ОУХМ	СМ	СДМ	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг
Нээлттэй холын зайд чөлөөт нислэг үйлдэх (км)	110	70	35	17	10	
Нээлттэй холын зайд нэг болон хэд хэдэн эргэлтийн цэг (turn point) дайран нислэг үйлдэх (км)	100	60	30	14	7	
Тодорхой цэг (goal) хүртэл холын зайн нислэг үйлдэх (км)	85	50	25	12	5	
Тодорхой цэг (goal) хүрээд буцаж гараан дээр ирэх (км)	70	30	12	9		
Гурвалжин маршрутаар нислэг үйлдэх* (км)	65	25	12	8		
25 км урттай гурвалжин маршрутыг богино хугацаанд туулах (км/цаг)		15				
Өндрийн нислэг (м)		3,500	2,000	1,000		
Нэг удаагийн урт хугацааны нислэг (цаг)				4	2	

**Тэмдэглэл: Гурвалжин маршрутын үед гурвалжны аль ч тал нь нийт уртын 28%-иас доошгүй урттай байх ёстой.*

3.1.2 ЦЭГТ ГАЗАРДАХ ТӨРӨЛ (ACCURACY)

Цэгт газардах төрөлд нэг тэмцээний үеэр хяналтын тойрог буюу 2 метрийн тойрог доторх хэмжилтийг үндэслэн амжилтыг тооцно. Хяналтын тойргийн гадна газардсан тамирчны амжилтыг хэмжихгүй.

Шалгуур	Цол зэрэг											
	ОУХМ		СМ		СДМ		1-р зэрэг		2-р зэрэг		3-р зэрэг	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Буултын тоо Хэмжих нэгж - см	5 <5	5 <10	5 <10	5 <20	5 <20	5 <30	5 <30	5 <40	5 <40	5 <50	5 <80	5 <100

3.1.2.1 Хүснэгтэд заасан оноог тэмцээний эхний 6 буултын аль нэг өндөр оноотой буултыг хасаж 5 буултын нийлбэр оноогоор тооцно.

3.1.2.2 Цол, зэргийн нормативын биелэлтийг зөвхөн FAI буюу Дэлхийн агаарын спортын холбооны Тэмцээн зохион байгуулах дүрмийн Ерөнхий бүлэг, Бүлэг 7: Нийтлэг зүйл, Бүлэг 7: Удирдамж ба загвар, Бүлэг 7А болон 7С-г баримтлан зохион байгуулагдсан тэмцээн дээр гаргасан амжилтыг тооцно.

ДӨРӨВ: СПОРТЫН ЦОЛ, ЗЭРГИЙН ШАЛГУУР ТОГТООХ ЗӨВЛӨЛ

4.1 МПХ-ны цол, зэргийн зөвлөл нь Тэмцээний зөвлөл байна. Тэмцээний зөвлөл нь 5-н хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн даргыг МПХ-ны удирдах зөвлөлөөр сонгож баталсан байна.

4.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаан нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус

хуралдаан зөвлөлийн даргын зарласнаар тухайн цаг хугацаанд хуралдаж хэлэлцсэн асуудлын талаар санал хурааж олонхын саналыг үндэслэн дүгнэлт гаргана.

4.3 Цол, зэргийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх асуудлыг МПХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцан ажиллана.

ТАВ: СПОРТЫН ЦОЛ, ЗЭРЭГ ОЛГОХ

5.1 МПХ-д гишүүнчлэлтэй клубүүд нь бүрийн 11-р дүгээр сарын 1-ны дотор болзол хангасан тамирчны мэдээллийг цол зэргийн зөвлөлд хүргүүлнэ.

5.2 Спортын цол, зэрэг олгох зөвлөл нь Биеийн тамир, спортын тухай хууль, Биеийн тамир, спортын улсын хорооны спортын төрөл, цолны ангилал тогтоох, цол, зэрэг олгох журмын дагуу Тамирчин, Шүүгчийн зэрэг олгуулах хүсэлтийг МПХ-оор дамжуулан Монголын агаарын спортын холбоонд албан бичгээр уламжилж, цол, зэргийн үнэмлэхийг олгоно.

5.3 Цол зэргийн болзол хангагч нь дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Цээж зураг /4х3 хэмжээтэй, JPG өргөтгөлтэй файл хэлбэрээр/
- Шагналт байр эзэлсэн өргөмжлөл хуулбар
- Тэмцээний албан ёсны баталгаажсан дүнгийн хуулбар
- Бүрэн бөглөсөн журмын хавсралт №1 Спортын цол, зэргийн болзол биелүүлсэн тодорхойлох анкет

5.4 Цол зэрэг биелүүлсэн тамичдын цол зэргийг МПХ-ны бүх нийтийн арга хэмжээн дээр гардуулна.

Журам баталсан

МПХ Удирдах зөвлөлийн гишүүд:

А.Батдаваа

Б.Болормаа

Н.Мөнхбаяр

П.Болд

С.Очхүү

Б.Дарамжав

П.Бэхболд

Г.Мөнхсайхан

Ц.Мягмардорж

Хавсралт №1

МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН ЦОЛНЫ БОЛЗОЛ БИЕЛҮҮЛСЭН ТАМИРЧИН, ШҮҮГЧДИЙГ ТОДОРХОЙЛОХ АНКЕТ

МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО

1	Овог нэр/ бүтэн бичнэ/	
2	Хүйс	
3	Аль хот, аймаг, суманд төрсөн	
4	Болзол хангасан спортын төрөл	
5	Спортын ямар цолд тодорхойлж байна	
6	Урьд нь авсан спортын цол	
7	Урьд авсан спортын цолны тогтоолын огноо	
8	Регистрийн дугаар	
9	Харьяа аймаг, нийслэл, дүүргийн БТСГ, клуб	
10	Одоо хаана ямар ажил эрхэлдэг	

Спортын цол, зэрэг биелүүлсэн байдал:

Он	Тэмцээний төрөл	Амжилт	Байр

Анкет үнэн зөв бөглөсөн:

Гарын үсэг ……/гарын үсгийн тайлал/

Спортын холбооны шийдвэр:

Спортын цол зэргийн нэгдсэн ангиллын …. р үзүүлэлтийг үндэслэн спортын…….. Цол олгуулахаар дэмжив.

Тамга,

Гарын үсэг Е.Н.Б.Дарга …… /гарын үсгийн тайлал/